


ECONOMIC POLICY AND COMPETITIVENESS  
RESEARCH CENTER

ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО, ӨРСӨЛДӨХ  
ЧАДВАРЫН СУДАЛГААНЫ ТӨВ



# Банкуудын өрсөлдөөний тойм

4-р улирал,  
2020



- ◇ Банкны салбарын мэдээ, мэдээлэл
- ◇ Үндсэн үзүүлэлтүүд
- ◇ Онцлох сэдэв: КОВИД-19 цар тахлын эсрэг Монголбанкаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ
- ◇ Арилжааны 12 банкны актив, зээл, хадгаламж, ашгийн хэмжээ

## БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2020 он – IV улирал

### Банкны салбарын эргэн тойронд

10.20 Голомт банк Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг түүчээлэгч аж ахуйн нэгжүүд, бизнесийн салбарын манлайлагчдад зориулан “FMC” /Financial Manager’s Convention/ арга хэмжээ болон “Business Conference” форумыг “New normal, New opportunity” буюу “Шинэ хандлага-Шинэ боломж” нэрийн дор зохион байгууллаа. Чуулга уулзалтад улсын эдийн засгийг тодорхойлогч, бизнесийн салбарыг түүчээлэгч 1000 гаруй аж ахуйн нэгж, тэдгээрийн удирдлагууд оролцжээ. [golombank.com](http://golombank.com)

10.20 Улсын Их Хурал, Засгийн Газрын хэрэгжүүлж буй зээлийн хүүг бууруулах хөтөлбөрийн хүрээнд ипотекийн зээлийг зорилтот бүлэгт чиглүүлэн агаар орчны бохирдлыг бууруулах, барилгын салбарыг дэмжих зорилгоор Орон сууцны ипотекийн зээлийн хүүг бууруулах шийдвэр гарсантай холбогдуулан Төрийн банк нь орон сууцны ипотекийн зургаан хувийн хүүтэй зээлийг олгож байна. [statebank.mn](http://statebank.mn)

11.20 “Euromoney” сэтгүүлээс Монгол Улсын 2020 оны “Шилдэг банк”-аар ХААН Банкныг тодруулснаар 11 дэх удаагаа хүртсэн тогтвортой, түүхэн амжилт үзүүлэв. Нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмэр, олон нийтэд зориулан нэвтрүүлсэн шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээ, шинэчлэл, нийгмийн хариуцлага, компанийн засаглал, санхүүгийн тогтвортой үзүүлэлт зэргийг үнэлэн “Euromoney” сэтгүүл жил бүр дэлхийн банк санхүүгийн салбарын шилдгүүдийг тодруулдаг билээ. [khanbank.com](http://khanbank.com)

12.09 БОГД Банк уул уурхайн бус экспорт болон жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг ААН-үүдэд хөнгөлөлттэй зээлийн бүтээгдэхүүн олгож эхэллээ. [bogdbank.com](http://bogdbank.com)

12.15 Олон улсын банк санхүүгийн салбарын нэр хүндийг тодорхойлогч “Global Finance” сэтгүүл 2020 оны дэлхийн шилдэг банкуудыг шалгаруулснаас Монгол Улсаас Голомт банк “Шилдэг Дижитал банк”-аар тодорлоо. Ингэснээр Голомт банк “Global Finance” сэтгүүлийн шагналыг 6 дахь удаагаа хүртэж байна. [golombank.com](http://golombank.com)

12.22 “Монголын тогтвортой санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд Монголбанк, ТоС холбооноос жил бүр Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн бодлогыг хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд ахиц дэвшил, амжилт гаргасан банкуудыг тодруулдаг уламжлалтай бөгөөд 2020 оны Шилдэг ТоС Банкаар ХасБанкийг шалгарууллаа. [xacbank.mn](http://xacbank.mn)


12.24 “Монголын Тогтвортой Санхүүжилтийн Хөтөлбөр”-ийн хүрээнд МонголБанк болон Тогтвортой Санхүүжилтийн (ТоС) Холбооноос жил бүр ТоС-ийн бодлогыг хэрэгжүүлэхэд онцгой ахиц дэвшил, амжилт гаргасан банкуудыг тодруулдаг билээ. Тус холбооноос 2020 оны “Онцлох ТоС Банк”-аар Голомт банк байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлага, ногоон зээл, ТоС-ийн сургалт хөгжил зэрэг ажлуудаараа манлайлан шалгарчээ. [golombank.com](http://golombank.com)

12.25 Төрийн 181 үйлчилгээг авах боломжтой E-Mongolia үндэсний цахим системд ХААН Банк нэгдлээ. Ингэснээр эрхэм харилцагч та энэхүү системээс төрийн үйлчилгээ авахаар хандахдаа ХААН Банкны интернэт банкны эрхээрээ нэвтрэн өөрийгөө зайнаас танин баталгаажуулалт хийх боломжтой болж байгаа юм. [khanbank.com](http://khanbank.com)

# БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2020 он – IV улирал

## Банкны салбарын гол үзүүлэлтүүд<sup>1</sup>



**Нийт актив = 36.6 их наяд төгрөг**

Банкны салбарын нийт актив 2020 оны 4-р улиралд 36.6 их наяд төгрөг болж өмнөх улирлаас 3.4 их наяд (0.8%) төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 2 их наяд (2.2%) төгрөгөөр тус тус өссөн байна.


**Алдагдал = 265.3 тэрбум төгрөг**

Банкуудын өөрийн хөрөнгө 2020 оны 4-р улирлын байдлаар 3.05 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.02 их наяд төгрөгөөр буурчээ. Харин банкны салбарын ашиг 4-р улирлын байдлаар 265.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байна.




**Банкны нөөц = 4.1 их наяд төгрөг**

Банкны нөөц 2020 оны 4-р улирлын байдлаар 4.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 2.1 их наяд төгрөгөөр буурчээ. Харин өмнөх улиралтай харьцуулахад 410 тэрбум төгрөгөөр буурсан байна.



**Чанаргүй зээл 12.6%**

Нийт дотоодын зээл (цэвэр) 2020 оны 4-р улирлын байдлаар 15.81 их наяд төгрөг болж өсөв. Чанаргүй зээлийн хэмжээ мөн өсөж 4-р улирлын байдлаар нийт чанаргүй зээл 1.9 их наяд төгрөг буюу нийт зээлийн (цэвэр) 12.6%-ийг эзэлж байна.



<sup>1</sup> Эх сурвалж: Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд, Монголбанк

# БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2020 он – IV улирал


## Ипотек = 4.91 их наяд төгрөг

Ипотекийн зээлийн үлдэгдэл 2020 оны 4-р улирлын байдлаар 4.91 их наяд төгрөг буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.4%-иар өссөн байна.




## 1 USD = 2849 MNT 1 CNY = 435 MNT

Монголбанкнаас зарласан ханшийн сарын дундаж хөдөлгөөнөөр 2020 оны 12-р сарын дундаж Ам.доллар-ын ханш 2849₮, Юань-ийн ханш 435₮ байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ам.долларын ханш 93₮-р (+3.3%), Юанийн ханш 41₮-р (+1%) тус тус өссөн байна.



## Харилцах+Хадгаламж=22.4 их наяд ₮

2020 оны 4-р улирлын байдлаар банкны салбарын нийт хадгаламжийн хэмжээ 17.24 их наяд төгрөг, харилцах 5.18 их наяд төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж 29%-иар өсөж, харилцах 4%-иар буурсан байна.



## Пассив = 33.6 их наяд төгрөг

2020 оны 4-р улирлын байдлаар банкны салбарын нийт пассив (өр төлбөр) 33.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 0.8 их наяд (2.4%) төгрөгөөр нэмэгджээ.



## Онцлох: КОВИД-19 цар тахлын эсрэг Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ

Олон улсын валютын сангийн хөтөлбөрийн хүрээнд, бусад төв банкуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг судалж, өөрийн орны онцлогт тохирсон бодлогын цогц арга хэмжээг Монголбанкнаас авч хэрэгжүүлж байна.

### 1. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, ханшийн эрсдэлийг бууруулах зорилгоор гадаад валютын своп хэлцлийг тогтмол хийж байна

Банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, валютын ханшийн эрсдэлээс хамгаалах, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг зорилгоор Монголбанк төгрөг-ам.долларын своп хэлцлийг банкуудтай тогтмол хийж байна. Монголбанк оны эхнээс богино хугацаат репо санхүүжилтээр оны эхний 9 сарын байдлаар 2.4 их наяд төгрөг, гадаад валютын своп хэлцлээр 1.7 их наяд төгрөгийн нөөцийг банк хоорондын захад нийлүүлээд байна.

### 2. Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журамд түр хугацааны өөрчлөлт оруулав

КОВИД-19 вирусын тархалттай холбоотойгоор Монгол Улсын эдийн засагт хүндрэл учирч, банкны салбарын зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсч байгаатай холбогдуулан Монголбанкнаас дараах журмуудын тодорхой зохицуулалтыг доорх нөхцөлтэйгөөр **түр хугацаагаар буюу** 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл мөрдүүлэхээр шийдвэрлэв. Энэхүү зохицуулалтын хүрээнд 10-р сарын 1-ний байдлаар 3.7 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийгдсэний 2.2 их наяд төгрөг нь бизнесийн зээл байна.

### 3. Эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг сунгах шийдвэр гаргалаа

Мөнгөний бодлогын хорооны ээлжит болон ээлжит бус хурлуудын шийдвэрээр эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргалаа. Энэхүү арга хэмжээ нь 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл зээлдэгчдийн зээлийн сарын төлбөрийн дарамт буурч гар дээр үлдэх орлого нэмэгдсэнээр хувийн хэрэглээг урамшуулах, улмаар үүсээд буй өнөөгийн хүндрэлийг зөөлрүүлэх, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх нөлөөтэй юм. Энэ хүрээнд 10-р сарын 1-ний өдрийн байдлаар 1.5 их наяд төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт орсон байна.

### 4. Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийн эргэн төлөлтийг түр хугацаагаар хойшлууллаа

Зээлдэгчийн зээлийн эргэн төлөх нөхцөлийг дахин өөрчлөх, эргэн төлөлтийн доголдолтой зээлийн ангилал, зээлийн түүхийг түр хугацаанд бууруулахгүй байх асуудлыг бие даан шийдвэрлэх боломжийг банкуудад олгоод байгаа билээ. 10-р сарын 1-ний өдрийн байдлаар нийт 38,152 зээлдэгчийн 2.0 их наяд төгрөгийн зээлийн төлбөрийг 6 сарын хугацаатайгаар хойшлуулсан.

### 5. Төв банкны хүүний коридорын өргөнийг нарийсгаж, бодлогын хүүгээс +/- 1 нэгж хувиар тогтоов

Мөнгөний бодлогын хорооноос 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдөр хүүний коридорыг +/- 1 өргөнтэй болгож нарийсгах шийдвэр гаргасан нь банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих, илүү бага хүүгээр Төв банкнаас репо санхүүжилт авах бололцоог бий болгох зорилготой юм.

# БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2020 он – IV улирал

## Банкуудын өрсөлдөөн

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2020 оны 4-р улирлын байдлаар банкны салбарт нийт 12 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор банкны системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк гэсэн 5 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно. Үүнд:

- Актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Ашиг

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-2 банк, бусад банкууд гэж ангилсан.



### АКТИВ

### БАНКУУД

#### ТОМ-3 БАНК

>5 их наяд төгрөг

Худалдаа хөгжлийн банк  
Хаан банк  
Голомт банк

#### ДУНД-2 БАНК

1-5 их наяд төгрөг

Хасбанк  
Төрийн банк

#### ЖИЖИГ БАНКУУД

<1 их наяд төгрөг

Чингис хаан банк  
Капитрон банк  
Үндэсний хөрөнгө оруулалтын банк  
Ариг банк  
Богд банк  
Кредит банк  
Тээвэр хөгжлийн банк


# БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2020 он – IV улирал




Тайлант хугацаанд тайланд орсон 12 банкны нийт актив 36 их наяд төгрөг байна. Том-3 банк нийт активын 75.1%, Дунд-2 банк 18.3%, жижиг банкууд 6.6%-ийг эзэлж байна.

1 жилийн өмнөх мөн үетэй харьцуулахад том-3 банкны актив 12%, дунд-2 банкны актив өөрчлөлтгүй бол жижиг банкуудын актив 16.1%-иар буурчээ.

## АКТИВ



Банкуудын активын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь



# БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ


2020 он – IV улирал

## ЗЭЭЛ




Зах зээлд эзлэх хувь, 4У'20

Тайлант хугацаанд тайланд орсон 12 банкны нийт зээлийн үлдэгдэл 16.4 их наяд төгрөг байна. Үүнээс 73.6%-г Том-3 банк, 18.4%-г Дунд-2 банк, 7.9%-г жижиг банкууд бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн хэмжээ Том-3 банк 8%-иар өссөн бол Дунд-2 банк 14%-иар, жижиг банкууд 13%-иар буурсан байна. Харин нийт дүнгээр авч үзвэл банкуудын зээлийн хэмжээ сүүлийн нэг жилд 0.4%-иар буурчээ.



## Зээлийн хэмжээ, тэрбум төгрөг болон өсөлтийн хувиар









## ХАДГАЛАМЖ БА ХАРИЛЦАХ

Тайлант хугацаанд тайланд орсон нийт 12 банкны харилцах ба хадгаламжийн хэмжээ 25.3 их наяд төгрөг байна. Үүнээс 75.5%-г Том-3 банк, 18.4%-г Дунд-2 банк, 6%-г жижиг банкууд эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 26%-иар, Дунд-2 банк 7%-иар харилцах ба хадгаламжийн хэмжээгээ тус тус нэмэгдүүлсэн бол жижиг банкууд 9%-иар бууруулсан байна. Нийт дүнгээр нь авч үзвэл харилцах болон хадгаламжийн хэмжээ 1.9%-иар өсчээ.






## Хадгаламж ба харилцахын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлт



## АШИГ

2020 оны 4-р улирлын байдлаар тайланд орсон 12 арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд нийт 291 тэрбум төгрөгийн ашигтай (татварын өмнөх дүн) ажиллажээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банкны ашиг 25%-иар буюу 87 тэрбум төгрөгөөр буурч 262 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Дунд-2 банкны ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 91%-иар өсөж 77.8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Харин жижиг банкуудын хувьд 47.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Банкуудын ашиг, алдагдал (тэрбум төгрөгөөр):



Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень 4У'20, Монголбанк
2. Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд 4У'20, Монголбанк
3. Монголбанкны ханшийн сарын дундаж хөдөлгөөн, Монголбанк
4. Арилжааны банкуудын улирлын санхүүгийн тайлан 4У'20
5. Арилжааны банкуудын зээлийн тайлан, 2020 оны 12-р сар